

ӨМӨЗО-НЫ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

ТҮМЭНЦЭЦЭГ. Г.ОТГОН*

Хятадын “Х таван жилийн төлөвлөгөө”-ний хугацаанд (2000-2005 он) ӨМӨЗО-ны эдийн засаг нь Хятадын баруун бүс нутгийн үндэстний цөөнхийн бүс нутгуудын дотор онцгойлон түргэн хөгжиж, хөгжлийн түүхийн шинэ шатанд хүрсэн байна.

Эдийн засгийн үзүүлэлт

Сүүлийн 10 жилд Өвөр Монголын эдийн засгийн ерөнхий хүчин чадал ихээр нэмэгдэж, ард олны амьжиргааны түвшин бүхий л талаараа сайжирсан жилүүд байлаа. ӨМӨЗО-ны аж ахуйн нийт бүтээгдэхүүний дотор үйлдвэрлэл, тариалан, худалдаа үйлчилгээний салбарын эзэлж байгаа хувиар 2000 онд 22.3%, 34.2%, 43.5% байсан бол 2005 онд 15.7%, 44.1%, 40.2% болж хувирсан байна. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн аж ахуй 10 хувиар өссөн гэж хэлж болно. Эрчим хүч, химийн үйлдвэр, төмөрлөгийн аж үйлдвэр, тоноглолийн үйлдвэр, мал тариалангийн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, шинэ техник зэрэг үйлдвэрлэл хөгжсөн нь ӨМӨЗО-ны эдийн засгийн өсөлтийн гол түлхэц хүчин зүйл болсон байна. Мал тариалангийн салбарын бүтцийг сайжруулсан нь тариалах аж ахуй голлож байснаа тэжээлийн аж ахуй руу шилжиж байна. Бүх хүн амын 47.2 хувь нь хот суурин газарт амьдрах болсон бөгөөд Хөх хот, Бугат хот, Ордос зэрэг хотуудын үйлдвэрлэлийн хэмжээ нь ӨЗО-ны 51.8 хувийг эзэлж байгаа нь ӨМӨЗО-ны эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөх хүч буюу “Бух тэрэгний толгой” гэж нэрлэж болохоор байна. Хувийн өмчийн хэвшлийн аж ахуй хурдан хөгжиж байгаа нь эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмрээ оруулж байна.

ӨМӨЗО-ны эдийн засгийн ерөнхий хүчин чадал нь ойрын жилүүдэд онцгой

түргэн нэмэгдэж, 2005 онд үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүн 382.28 тэрбум юаньд хүрсэн нь 2000 оныхтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн бөгөөд жилийн дундаж өсөлтийн хурдац нь 16.6 хувь байж, нэг хүнд ногдох ҮНБ хэмжээ 1900 ам.доллараас давсан нь бүх улсын дундаж түвшингээс өндөр байна.

ӨМӨЗО-ны санхүүгийн нийт орлого нь 2000 онд 15.56 тэрбум юань байсан бол 2005 оны байдлаар 53.63 тэрбум юаньд хүртлээ өсч, жилийн дундаж өсөлтийн хэмжээ нь 28 хувьд хүрсэн байлаа. Үл хөдлөх хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь 5 жилд 691.8 тэрбум юань хүрч, дэд бүтэц харьцангуй сайжирч байгааг харуулж байна. Шинээр 10000 гаруй км автозам засч, 1000 гаруй км дээд хурдцын замтай болж, ӨМӨЗО-ны зүүн баруун бүс нутгийг холбосон авто замтай болсон байна. Мөн зүүн баруун бүс нутгийг холбосон цахилгаан сүлжээ, төмөр замын сүлжээг ашиглалтанд оруулах ажлыг эхлүүлээд байна.

Олон үндэстэн ард түмний ахуй амьдралын түвшин харьцангуй дээшилж, 2005 онд ӨЗО-ы хот суурин газарт оршин сууж байгаа иргэдийн нэг хүнд ногдох цэвэр орлогын хэмжээ 9137 юань, малчин тариачдын орлогын хэмжээ 2989 юань байгаа нь 2000 онтой харьцуулахад 78.1 ба 46.7 хувиар нэмэгдсэн байна. Хот хөдөөгийн иргэдийн хадгаламжийн хэмжээ 2.2 дахин өсч, амьжиргааны хэрэглээний бүтээгдэхүүний худалдааны орлого ойролцоогоор 2 дахин өссөн байна.

Үндэстний цөөнхид хэрэгжүүлэх төрийн бодлого

Өөртөө Засах Орны Засгийн газар үндэстний цөөнхид авах төрийн бодлогоо

* Түмэнцэцэг- Өвөр Монголын Их Сургуулийн профессор,
Г.Отгон- Монгол Улсаас ӨМИС-д суралцаж буй магистрант.

улам бүр хөнгөлттэй болгож, цогц арга хэмжээг явуулсан бөгөөд энэ нь ядуу амьдралтай үндэстний цөөнхийн ард түмний аж төрөх болон амьдрах нөхцөлийг бодитойгоор сайжруулжээ. Жишээлбэл: ӨЗО-ноос үндэстний цөөнхийн суурьшин амьдарч байгаа хил хязгаарын хошуу, саяний хөгжлийг түргэтгэх шийдвэр гаргаж, үндэстний цөөнхийн суурьшиж байгаа орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжин ахиулсан байна. Эвэнк, орчоон, дагуур гурван үндэстний нэн цөөнхийн хошуудад эдийн засгийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, олон талаар туслан тэтгэсээр байна. ӨЗО-ны харьяат байгууллагууд үндэстний цөөнхийн төвлөрөн суусан орон нутгийн хошуу сяньтай гэрээ байгуулж, туслалцаа үзүүлж, нийт орон нутаг дахь үндэстний цөөнхийн ядуурлыг бууруулахаар гол анхаарлаа төвлөрүүлсэн юм. ӨЗО-ны статистикийг үндэслэвэл, 2000 оноос ӨЗО-ы үндэстний цөөнхийн төвлөрөн суурьшсан орон нутгийг дэмжих төслийн тоо 715-д хүрч, хөрөнгө оруулалтын хэмжээ нь 5.7 тэрбум юаньд хүрчээ. Эдгээр орон нутагт цахилгаан, ус, зам харилцаа нэвтэрч, телевизийн нэвтрүүлэг үзэх боломжтой болсон бөгөөд нэн ялангуяа өөрийн онцлогт аж үйлдвэрийг хөгжүүлж чадсан байна.

ӨМӨЗО-ны эдийн засгийн хөгжилд нөлөөлөх давуу тал

ӨЗО-ны эдийн засгийн хөгжилд идэвхи нөлөө үзүүлж чадах давуу нөхцөлүүд:

1. Эх баялгийн давуу нөхцөл.

Өвөр Монгол нь бүх Хятадын хэмжээнд авч үзвэл, байгалийн эх баялгаар элбэг бүс нутгуудын нэг болно. Эх баялаг нь нөөц ихтэй төдийгүй олборлох болон нээн гаргах нөхцөл ч сайтай. Бэлчээр, ой мод болон нэг хүнд ноогдох тариалангийн талбайгаараа бүх Хятадын хэмжээнд нэгдүгээрт ордог. Газар доорх баялгийг хэлбэл, нөөцийн хэмжээгээрээ дэлхийд эхний байрыг эзэлдэг ховор шороо байхаар барахгүй, нүүрсний нөөцийн хэмжээ нь 220 тэрбум тонн байхаар илэрсэн бөгөөд үүгээрээ улсдаа хоёрдугаар байрыг эзэлж байна. Сүрэг хэмээх байгалийн хийн ордын нөөцийн хэмжээ нь 700 тэрбум орчим м³ байхаар илэрсэн нь дэлхий хэмжээний том байгалийн хийн ордод тооцогдох болно,

энэ нь мөн л зүүн бүс нутгаас баруун тийш байгалийн хийг зөөвөрлөх чухал эх сурвалжуудын нэг болж байна.

2. Байршлын давуу тал.

Өвөр Монгол нь Орос, Монгол улстай хил залгаа, 4200 км хилийн шугамтай, 18 хилийн боомттой, түүний дотор Манжуурын боомт нь Хятадын хамгийн том хуурай замын боомт болж, Эрээн хот боомт бол Хятад, Монгол улсын хоорондох хамгийн том боомт юм. Ойрын жилүүдэд тус ӨЗО болон Орос, Монгол хоёр улсын хоорондын эдийн засаг, техник технологийн харилцаа, хамтын ажиллагаа өдрөөс өдөр нягтарч байгаа юм.

Өвөр Монгол нь Хятадын зүүн хойд, хойд, баруун хойд бүс нутгийн хуваарилалд оршиж байгаа бөгөөд 8 хөрш муж, Бээжин, Тяньжин хоттой ойр байршил, нөхцлөөрөө эдгээр орон нутагтай эдийн засаг, техник технологийн хамтын ажиллагаагаа нягтруулж, зүүн баруун бүс нутгийг холбон хөгжүүлэх гео-эдийн засгийн давуу талтай юм.

3. Газар уудам, хүн ам сийрэг давуу тал

Өвөр Монголын газар нутаг өргөн уудам, хүн ам харьцангуй цөөн. Үүнтэй холбоотойгоор үйлдвэрлэх хүчнийг тохируулах боломжтой, хөдөлмөрийн хүчийг шилжүүлэх, хот суурьшуулах, байгалийн тэнцвэрт харьцааг хамгаалан сэргээн ашиглах давуу талуудтай. Өвөр Монгол нь шинээр хөгжиж байгаа бүс нутаг болохоор аж үйлдвэр хөгжүүлэхэд өндөр технологийн эхлэлттэй байж болох талтай, улсын дотоод гадаадын шинээр нэвтэрч байгаа техник технологийг ашиглах боломж сайтай, хамгийн шинэ техник технологи, тоног төхөөрөмжөөр эдийн засгаа түргэн хөгжүүлж болох давуу талтай юм.

Үүний зэрэгцээ Өвөр Монгол нь үндэстний цөөнхийн орон болсны хувьд, улсаас үндэстний цөөнхийн эдийн засгийг дэмжих төрийн бодлогын давуу талтай. ӨЗО-ы баруун хэсэг нь улсын баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх төрийн бодлогыг хүртэж, зүүн хэсэг нь улсын зүүн хойд бүс нутгийн аж үйлдвэрийн суурин газрыг дахин сэргээх төрийн бодлогыг ашиглах боломж байна. Энэ нь Өвөр Монголын хөгжилд их ашигтай сайн нөхцөл болж байгаа юм.

Өвөр Монголын өнөөгийн эдийн засгийн хөгжилд тулгамдсан асуудал

Хэдийгээр Өвөр Монгол нь “X таван жилийн” хугацаанд нийгэм, эдийн засаг хангалттай хөгжсөн боловч угаас суурь тааруу болохоор хөгжлийн түвшин доогуур, эдийн засгийн хөгжилд тулгарч байгаа асуудал бас маш олон байсаар байна. Жишээлбэл:

-Үйлдвэрлэх хүчний хөгжил дутмаг, эдийн засгийн гадагш хандах чадвар доогуур, худалдан авах, экспортлох чадвар нь эдийн засгийг өөд нь татахад хангалттай биш байдаг.

-Эдийн засгийн бүтэц тохиромжтой бус, аж үйлдвэрлэлийн түвшин бас л доогуур байсаар, улсын өмчийн бус аж ахуйн хөгжил удаан, өөрийн хүчээр шинийг үүсгэн бүтээх чадвар сул, үйлдвэрлэлийн техник технологийн түвшин доогуур, эдийн засгийн өсөлтийн арга хэлбэр нь харьцангуй бүдүүлэг байдаг.

-Эх баялгийг ерөнхийд нь ашиглах чадвар өндөр биш, аж үйлдвэрлэлийн бүлэглэн хөгжих талаар тааруухан, жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил хоцрогдонгуй байна.

-Хот хөдөөгийн хөгжил нь тэнцвэргүй, хот хөдөөгийн иргэдийн орлогын зөрүү ихсэж, экологийн тэнцвэрт байдал алдагдаж, дэд бүтэц хоцрогдонгуй тэр дундаа газар тариалан, мал аж ахуйн салбар болон малжих тариалах орон нутгийн дэд бүтцийн бүтээн байгуулалт хоцрогдонгуй байна.

Дээрхи асуудлаас харахад, Өвөр Монголын эдийн засгийг бүх талаар хөгжүүлэх үүрэг нэлээн хүнд хүчир байгаа. Иймд өөрчлөлт шинэчлэлтийг улам эрчимжүүлэх шаардлагатай байна.

Өвөр Монголын “XI таван жил”-ийн төлөвлөгөөний хугацаанд эдийн засгаа хөгжүүлэх арга хэмжээнүүд

“XI таван жил”-ийн хугацаанд, Өвөр Монгол нь гурван талаас эдийн засгийн хөгжлийг зохицуулан, цаашдын тогтвортой хөгжих замд нь оруулахаар төлөвлөж байна.

Нэгдүгээрт. Эдийн засгийн бүтцийг сайжруулж, олон улсын зах зээл болон улсын дотоодын зах зээлд өрсөлдөх чадвараа улам бүр сайжруулах.

Шинэ төрлийн аж үйлдвэрлэл, тариалан, мал аж ахуйн болон хотжилтыг сайжруулах гурван талыг баримтлах хэрэгтэй байна. Үүний тулд доорхи хэдэн ажилд гол анхаарлаа тавих хэрэгтэй байна гэж эрдэмтэд үзэж байна. Үүнд:

1. Мал тариалангийн аж ахуй ба хөдөө тосгоны нийгмийн ажлыг улам сайжруулж, шинэ хөдөө тосгон суурин газрыг байгуулах ажлыг эрчимтэй хөгжүүлэх.

2. Аж үйлдвэрийн эдийн засгийн нийт хүчин чадлыг нь дээшлүүлж, шинэ маягийн аж үйлдвэрлэлийг бий болгох. Улсын макро эдийн засгийн бодлогод нийцүүлэн онцлог бүхий аж үйлдвэрийг эрчимтэйгээр хөгжүүлэх, үйлдвэрлэлийн бүтцийг шат дараатайгаар сайжруулах.

3. Худалдаа үйлчилгээний аж үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд тус дөхөм үзүүлэх, орчин үеийн үйлчилгээний салбарыг хурдан бий болгох.

4. Хотжилтын явцыг түргэтгэж, хот хөдөөгийн хоорондын эдийн засгийн харилцааг ахиулахад тус дөхөм үзүүлнэ.

Хоёрдугаарт. Эдийн засгийн хөгжлийн арга хэлбэр, чанарыг сайжруулж, тогтвортой хөгжлийн замд нь оруулах.

1. Эрчим хүчний эх баялгийг нээн ашиглах түвшинг сайжруулах, эх баялгийг аривтай хэрэглэх нийгмийн хэв шинжийг бүтээн байгуулна.

2. Эргэлтийн эдийн засгийг (循环经济) эрчимтэй хөгжүүлж, эх баялаг, байгаль орчноо сайтар хамгаалж ашиглах.

3. Экологийн тэнцвэрт байдлыг хамгаалахыг эрхэмлэж, байгаль орчинд найрсаг хандах нийгмийн хэв шинжийг чухалчлах.

Гуравдугаарт. Шинжлэх ухаанчаар хөгжүүлэх онолыг туушлуулах тогтолцооны баталгааг сайжруулах,

бүх талаар нээлттэй байх байдлыг бий болгоно.

1. Засаг захиргааны өөрчлөлт, улсын байгууллагын өөрчлөлт, хөдөө орон нутгийн ерөнхий өөрчлөлт, хөрөнгө оруулалт, санхүү, банкны өөрчлөлтийг эрчимжүүлнэ.

2. Эдийн засгийн гадаад харилцаагаа сайжруулахын тулд бүх талаар нээлттэй бодлогоо үргэлжлүүлэх.

3. Дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарч, хөгжлийн орчин ахуйг улам сайжруулна.

Дээрхи арга хэмжээг “ХИ таван жил”-ийн хугацаанд сайн хэрэгжүүлж чадвал ӨМӨЗО-ын нийгэм, эдийн засаг улам ихээр хөгжих боломжтой.

Ашигласан материал:

1. Чү Бө "Өвөр Монголын нийгэм, эдийн засгийн хөгжилтийн төлөө чармайя" 《为实现内蒙古经济社会发展而努力奋斗, www.nmgnews.com 2005.08.05

2. Ян Жин "Бүх талаар тогтвортой хөгжилтийн замаар урагшилъя" 《坚持走全面可持续发展的道路》, www.nmgnews.com 2006.03.11

3. "Өвөр Монголын өдрийн сонин" 2006 оны1-3 сарын дугаарууд.